

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотод такси үйлчилгээ эрхлэх нөхцөл, боломжийг сайжруулах, холбогдох стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч	-Нийслэлийн Засаг даргын ахлах зөвлөх
Гишүүд:	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
	-Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга;
	-Нийслэлийн Газрын албаны дарга;
	-Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга;
	-Замын цагдаагийн албаны Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын дарга;
	-“Замын хөдөлгөөний удирдлагын төв” НӨҮГ-ын дарга;
	-“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн гүйцэтгэх захирал;
	-“ЦББ” ХХК-ийн такси эрхэлсэн захирал /тохиролцсоноор/;
	-“УБТТС” ХХК-ийн гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;
	-“Мөнх такси” ХХК-ийн гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/.

дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн;
такси	-Нийслэлийн Нийтийн тээврийн газрын үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан саналыг боловсруулж, 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД